



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2020.01.30 № 1/233  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2019 оны биелэлтийг гаргаж, Дотоод аудит, мониторингийн газраар үнэлүүлэн хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 11 хуудастай.

ДАРГА

Д.ЗОРИГТ



**Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газраас  
2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт**

№	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Биелэлт	Үнэлгээ
1	Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх	<p>Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч, ажилтан, ажил олгогч болон даатгуулагч-үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг үнэлэх арга хэмжээг зохион байгуулах, санал, дүгнэлт боловсруулах.</p> <p>Төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор төрийн байгууллагууд /Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар,</p>	<p>Аймаг, дүүргийн НДХ-тэй хамтран ажил олгогч, даатгуулагч болон нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудын сэтгэл ханамжийг үнэлж, санал боловсруулсан байна</p> <p>Иргэдэд төрийн үйлчилгээ чирэгдэлгүй үзүүлэх ажил сайжирсан байна.</p>	<p>2019 онд сэтгэл ханамжийн судалгаа авах арга хэмжээг 3 удаа зохион байгуулсан ба 5892 иргэн, даатгуулагч, 1001 байцаагч, ажилтан хамрагдав. Уг судалгаануудын санал, тайлан, үр дүнгүүдийг удирдлагад танилцуулав.</p> <p>“Танд урьдчилан зөвлөө” аяныг нийгмийн даатгалын салбарын хэмжээнд зохион байгуулж, Жилийн эцсийн байдлаар 25761 тэтгэвэр тогтоолгох даатгуулагчдын баримт бичгийн бүрдлийг шалгаж, зөвлөгөө мэдээлэл өгч, 5524 иргэнд лавлагаа гарган өгсөн байна. Зөвлөгөө авсан 11211 даатгуулагч иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгааг дүгнэхэд зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээг 92,1% нь маш сайн, 88,3% мэдээлэлээ бүрэн авч чадсан, 79,3 % нь аяны мэдээллийг нийгмийн даатгалын хэлтсээс, 75,5 % нь зөвлөмжийн хуудас авснаар, зөвлөгөө өгсөн ажилтны үр чадварыг 89,1 % нь хангалттай гэсэн үнэлгээ өгсөн байна. .</p> <p>Мөн иргэд, даатгуулагчдаас цахим үйлчилгээ, мэдээллийн эх сурвалжийн талаар онлайнаар судалгаа авах линкийг нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудын цахим хуудсанд байршуулж судалгааг авч байна.</p> <p>1.Нийгмийн даатгалын байгууллага нь Архивын ерөнхий газартай нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор 2017 онд байгуулсан Хамтран ажиллах гэрээг боловсронгуй болгох чиглэлээр санал авхаар АЕГ-т 2 удаа хүсэлт явуулсан.</p> <p>Энэхүү гэрээний хэрэгжилтийн хүрээнд архивын</p>	100

		<p>Архивын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар зэрэг/-тай цахимаар мэдээлэл солилцох, хамтран ажиллах</p>		<p>лавлагааг хуурамчаар үйлдэх, нийгмийн даатгалын санг хууль бусаар ашиглах явдлыг зогсоох, лавлагааг нууцлалтай болгох, хяналтыг сайжруулах зорилгоор Архивын ерөнхий газар болон Нийслэлийн архивын газар, Цэргийн 9 байгууллагын архивын сан хөмрөгт байгаа байгууллагын захирамжлалын болон цалин, хөлсний баримтаас гаргасан архивын лавлагааг иргэдийн гараар дамжуулахгүй цахим байдлаар авахад Тагнуулын ерөнхий газарт холбогдох хүсэлтийг тавьж, зөвшөөрлийг авч, хамтран ажиллах талаар санал боловсруулан АЕГ-т хүргүүлсэн.</p> <p>Мөн аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд ирсэн архивын хуурамч лавлагааны талаарх болон улсын архивт шилжүүлэх шаардлагатай хувь хүн болон хуулийн этгээдэд хадгалагдаж байгаа архивын баримтын талаарх судалгааг авч, эдгээр мэдээллийг Архивын ерөнхий газарт хүргүүлэн хамтран ажиллаж байна.</p> <p>2. Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газартай байгуулсан “Мэдээлэл солилцох гэрээ”-нд 2019 онд нэмэлт өөрчлөлт оруулан 11 төрлийн мэдээлийг тус газарт цахимаар хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>3. Улсын бүртгэлийн ерөнхий газартай байгуулсан “Мэдээлэл солилцох гэрээ”-ний дагуу хуулийн этгээдийн бүртгэлийн 6, иргэний бүртгэлийн 3 төрлийн мэдээллийг цахимаар авч ажиллаж байна.</p> <p>4. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан гэрээг шинэчлэн байгуулсан 2019 оны А-02/НД47 тоот “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу эрүүл мэндийн даатгалтай холбоотой 9 төрлийн мэдээллийг цахимаар солилцон ажиллаж байна.</p>	
		<p>Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор Архивын ерөнхий газар, нийслэл, орон нутгийн, цэргийн архивын байгууллагуудаас архивын лавлагааг цахимаар хүлээн авах ажиллагааг эхлүүлэх, хамтран ажиллах</p>	<p>АЕГ болон төрөлжсөн архивуудтай хамтран ажилласан байна.</p>	<p>Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх, архивын лавлагааг хуурамчаар үйлдэх, нийгмийн даатгалын санг хууль бусаар ашиглах явдлыг таслан зогсоох, лавлагааг нууцлалтай болгох, хяналтыг сайжруулах зорилгоор Архивын ерөнхий газар, Нийслэлийн архивын газар, Батлах хамагаалах яамны төв архив, Зэвсэгт хүчний жанжин штабын архив, Цагдаагийн ерөнхий газрын төв архив, Хилийн цэргийн төв архив, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын архив, Онцгой байдлын ерөнхий газрын архив, Тагнуулын ерөнхий газрын архив, Дотоодын цэргийн штаб, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Авлигатай тэмцэх</p>	

				<p>газарт хамтран ажиллах санал хүргүүлсэн.</p> <p>Энэхүү хүсэлтэд төрийн болон цэрэг, цагдаагийн байгууллагын төрөлжсөн архиваас гаргаж байгаа алба хаагчийн цэргийн алба хаасны болон ажилласан жил, цалингийн лавлагааг хэрхэн гаргах, лавлагааг нууцлалтай болгох, хяналтыг сайжруулах зорилгоор цахимаар солилцох мэдээллийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэх талаар тодорхой тусгасан.</p> <p>Дээрх байгууллагуудаас ЦЕГ, ШШГЕГ, ОБЕГ, ДЦШ байгууллагуудаас хамтран ажиллах хариу ирж холбогдох саналыг боловсруулан, хамтарсан ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна. ТЕГ, АТГ газруудаас мэдээллийг цахимаар солилцох боломжгүй талаар хариу ирсэн. АЕГ, НАГ, БХЯ, ШШҮХ, ХХЕГ-аас хариу ирүүлээгүй байна.</p>	
2	<p>Өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх</p>	<p>Нийгмийн даатгалын мэдээллийн лавлах 77771289 утасны үйл ажиллагааг өргөжүүлэх, байгууллагын цахим хуудас, FB хуудсанд ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэлд цахим хэлбэрээр хариу өгөх, шийдвэрлэхэд хяналт тавих</p>	<p>Цахим үйлчилгээ сайжирсан байна</p>	<p>Иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх санал хүсэлтийг:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. <a href="http://www.ndaatgal.mn">www.ndaatgal.mn</a> цахим хуудас,</li> <li>2. 77771289 лавлах утас,</li> <li>3. “Нийгмийн даатгал” гар утасны аппликейшн, бичгээр,</li> <li>4. иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан хүлээн авч байна.</li> </ol> <p>Тайлант хугацаанд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын <a href="http://www.ndaatgal.mn">www.ndaatgal.mn</a> вэбсайтын “Санал хүсэлт” буланд иргэд-даатгуулагчаас 694 санал хүсэлт, асуулт,</li> <li>2. Нийгмийн даатгалын лавлах 7777-1289 дугаар утсанд орж ирсэн дуудлагаас нийтдээ 135450 нь дуудлаганд хариу өгч ажилласан.</li> <li>3. “Нийгмийн даатгал” аппликейшнээр 841 санал хүсэлт ирсэнийг ажлын 5 хоногт багтаан хариуг иргэд, даатгуулагчид утсаар болон и-мэйл хаягаар нь хүргүүлж ажиллалаа. /нийт 1535/</li> <li>4. Мөн иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд ирсэн 103 асуултын хариуг иргэдтэй нь утсаар холбогдон цаг тухайд нь өгсөн</li> </ol> <p>Мөн Даатгуулагч, иргэдээс нийгмийн даатгалын лавлах 9490-1289 дугаар утсанд нийтдээ 4968 дуудлаганд хариу өгч, интернэт орчинд харилцах программ болох Wechat-аар 303, Viber-аар 716, и-мэйлээр 1631 иргэн хандаж бүгд мэдээ мэдээлэл, заавар зөвлөгөө авсан байна. Гар утасны аппликейшний код олголтыг цахимаар нийт 2571,</p>	100

				үүнээс гадаадаас 68 иргэнд олгосон байна.	
3	Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох	Хяналт шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор хийнэ	Нийгмийн даатгалын үйлчилгээнд хяналт тавина	НДЕГ-ын 2019 оны А/50 дугаар тушаалаар “Цахим хяналтын программын ажлын заавар”-ыг батлан мэдээлэлд тулгуурлан хийх хяналт шалгалтыг тогтмолжуулж, дүн мэдээг шуурхай ирүүлж байхыг үүрэгжүүлж ажилласан. Аймаг, дүүргийн хяналт шалгалт, дотоод аудитын тасагтай хамтран зөрчилтэй байх магадлалтай шимтгэлийн тайлан авалт, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн тогтоолт, олголт, ажилгүйдлийн тэтгэмжийн олголтод нийт 16 хувилбараар энэ оны эхний 11 сарын байдлаар 21 аймаг, 9 дүүргийн 95240 даатгуулагчийн мэдээлэлд Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын систем”-( <a href="http://10.9.0.5/monitoring">http://10.9.0.5/monitoring</a> )-д тулгуурлан шалгалт хийлээ. Шалгалтын явцад зөрчил гарсан шалтгаан үндэслэлийг анхан шатны баримт болон мэдээллийн нэгдсэн сантай нэг бүрчлэн тулган шалгаж нийт мэдээллийн 88,1 хувь буюу 83906 даатгуулагчийн мэдээлэлд залруулга хийж тайлбарласан. Цаашид алдаатай мэдээллийг гаргахгүй байхад анхаарч, зайлшгүй алдаа гарсан тохиолдолд анхан шатны баримтыг үндэслэн засварлаж, тайлбарыг цаг хугацаанд нь хийж ажиллах талаар үүрэг өглөө. Цахим хяналтын системийг хэрэгжүүлж үр дүнг сайжруулах чиглэлээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/50 дугаар тушаалаар “Цахим хяналт шалгалтын ажлын заавар” батлуулж хэрэгжилтийг улирал бүр гаргуулж дүнг нэгтгэн хяналт тавин ажиллаж байна. Мөн “Эрсдэлд суурилсан цахим хяналтын тогтолцоог нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтад 21 аймаг, 9 дүүргийн хяналт шалгалт, дотоод аудитын 160 гаруй ажилтнуудыг хамруулан Цахим хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хөндлөнгийн хяналтын байгууллагуудын ажлын туршлагаас суралцах зэрэг чиглэлээр мэдээлэл өглөө.	100
4	Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаархи судалгааг тогтмол хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах	Нийгмийн даатгалын үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгааг авах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах	Журам батлагдаж, аймаг, дүүргийн НДХ-т хүргэгдэн, сэтгэл ханамжийн судалгаа авсан байна.	НДЕГ-ын даргын 2015 оны А/172 тоот тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгаа авах журам”-ыг шинэчлэх ажлын хүрээнд Сэтгэл ханамжийн судалгаа авах журмын төслийг боловсруулсан. Уг журмаар сэтгэл ханамжийн судалгаа авах арга хэлбэр, судалгааны төрлүүдийн нарийн дурьдсан болно.	95
5	Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг тоон гарын үсэг ашиглан	Тоон гарын үсэг өгөх зөвшөөрөлтэй 4 байгууллагын олгосон	Ажил олгогчоос тоон гарын үсгээр баталгаажуулан илгээсэн тайланг нийгмийн даатгалын байцаагч QR кодтойгоор нь хэвлэн авах боломжийг бүрдүүлсэн.	97.9

<p>тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх</p>	<p>хүлээн авах, баталгаажуулах ажлыг өргөжүүлэх</p>	<p>гарын үсэг ашиглан нийгмийн даатгалын тайланг цахимаар ирүүлэх боломж бүрдэнэ.</p>	<p>Шинээр тоон гарын үсэг олгогч байгууллагуудын тоон гарын үсгээр баталгаажуулан илгээсэн ажил олгогчдын тайланг хүлээн авах өргөтгөл хийж, Тридум компаниас олгож буй тоон гарын үсгийг ашиглан илгээсэн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг хүлээн авах боломжийг бүрдүүлэн туршилт хийж, нэвтрүүлээ. Одоогийн байдлаар 29 нэгжийн 1615 ажил олгогч тоон гарын үсгээр баталгаажуулсан тайлан илгээснээс 1516 тайланг нийгмийн даатгалын байгууллага хүлээн авсан байна.</p>	
	<p>Нийгмийн даатгалын өгөгдлийн санг цуглуулах, нэгтгэх, нөөцлөх, хадгалах болон иргэд, даатгуулагчид, төрийн байгууллагуудад мэдээллийн үйлчилгээ үзүүлэх</p>	<p>Иргэд, даатгуулагч, ажил олгогчид нийгмийн даатгалтай холбоотой мэдээ, мэдээллээр хангасан байна. Мэдээллийн аюулгүй байдал хангагдсан байна.</p>	<p>Мэдээллийн санг өдөр тутам цуглуулан нэгтгэснээр Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 159 тоот тогтоолоор баталсан “Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”, 2018 оны “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх арга хэмжээний тухай” 259 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Үндэсний Дата төв, Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээр дамжуулан 10-аад төрийн байгууллагуудыг цахим мэдээллээр хангах ажил тогтмол хийгдэж байна. 2019 онд төрийн байгууллагууд 2673.4 мянган хандалтыг мэдээллийн санд хийсэн байна.</p> <p><b>Мэдээллийн боловсруулалт хийх ажлын хүрээнд:</b> Удирдах дээд байгууллага болон харилцагчдын хүсэлтээр нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сангаас 230 гаруй мэдээллийн боловсруулалт хийж хэрэглэгчдийг шаардлагатай мэдээллээр ханган ажиллалаа.</p> <p><b>Төрийн байгууллагатай цахимаар мэдээлэл солилцох ажлын хүрээнд:</b> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 159 тоот тогтоолоор баталсан “Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”, 2018 оны “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 259 тоот тогтоолын дагуу төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан дараах төрийн байгууллагуудыг цахим мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна. Үүнд:</p> <p>Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 5 төрлийн 38 гаралт мэдээлэл, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт иргэд даатгуулагчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эсэх мэдээлэл, Татварын ерөнхий газарт татвар болон нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн байгууллагуудын регистрийн дугаар, нэр, үйл ажиллагааны чиглэл, хаяг байршил болон даатгуулагчийн /ажилтнуудын/ тоо, цалингийн сангийн мэдээлэл, Тагнуулын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Авлигатай тэмцэх</p>	

				<p>газар, Эрүүл мэндийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Эрчим хүчний яам, Сангийн яам, Авто тээврийн үндэсний төв, Монгол банкны Зээлийн мэдээллийн сан зэрэг төрийн томоохон байгууллагуудыг цахимаар мэдээлэл солилцох гэрээний дагуу тогтмол мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p><b>Иргэд, даатгуулагчдад 3-аас доошгүй сувгаар цахимаар мэдээлэл хүргэх ажлын хүрээнд:</b></p> <p>Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод “Нийгмийн даатгал” гар утасны аппликейшн, “Даатгуулагчийн бүртгэл вэб програм хангамж” болон Төрийн үйлчилгээний 109 цахим машинаар шаардлагатай мэдээллүүдийг нь цахимаар цаг тухай бүр түргэн шуурхай хүргэх ажил тогтмол хийгдэж байна. Тухайлбал:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Иргэд даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээний 4 төрлийн томоохон мэдээллийг гар утсаараа харах “Нийгмийн даатгал” аппликейшийг одоогийн байдлаар 133.1 мянган даатгуулагч гар утсандаа суулгаж, 81.2 мянган даатгуулагч эрхээ баталгаажуулан идэвхтэй ашиглаж байна. Эдгээрээс 0.9 мянган хэрэглэгч онлайнээр эрхээ баталгаажуулжээ.</li> <li>2. Иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээний 4 төрлийн томоохон мэдээллийг интернэт сувгаар хүргэх ажил амжилттай хэрэгжиж, одоогийн байдлаар 31.9 мянган даатгуулагч интернэтээс QR кодтой “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт”-оо хэвлэн авсан байна. Мөн иргэд даатгуулагч нийгмийн даатгалын байгууллагад гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээллээ цахимаар харах ажил тогтмол явагдаж байгаа бөгөөд 4.0 мянга гаруй иргэний өргөдөл цахим мэдээлэлд бүртгэгдэж, 2.0 гаруй мянган даатгуулагчийн өргөдөл шийдвэрлэгдсэн мэдээлэл иргэнд мессежээр илгээгдсэн байна.</li> </ol> <p>Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээр дамжуулан иргэд даатгуулагч, ажил олгогчид төрийн үйлчилгээний цахим /ТҮЦ/ машинаар олгож буй 4 төрлийн лавлагаа тодорхойлолтыг өгөх ажил тогтмол хийгдэж, одоогийн байдлаар нийтдээ 484.4 мянган лавлагаа, тодорхойлолтыг ТҮЦ машинаас хэвлэн авсан байна.</p>	
		<p>Сайн дурын даатгалын гэрээг цахим хэлбэрээр байгуулах ажлыг зохион байгуулах, мэргэжил, арга</p>	<p>Аймаг, дүүргийн НДХ-үүдийг мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан байна.</p>	<p>ХНХС-ын 2019 оны А/01 тоот тушаалаар “Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээ”-ний загварыг шинэчлэн баталсантай холбоотой Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2019 оны А/61 тоот тушаалаар</p>	

		зүйгээр ханган ажиллах		<p>“Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахад баримтлах журам”-ыг шинэчлэн баталж холбогдох өөрчлөлтийн талаар төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлэн мэргэжил, арга зүйгээр ханган, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.</p> <p>Энэхүү ажлын үр дүнд сайн дурын даатгалын гэрээг цахимаар байгуулах, сунгах, цуцлах ажлыг эхлүүлэн програм хангамжид өөрчлөлт оруулах програмын даалгаврыг Мэдээллийн технологийн төвд тухай бүр хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Сайн дурын даатгалын гэрээг цахимаар байгуулах, сунгах, цуцлах талаарх ажлыг програм хангамжид өөрчлөлт оруулах 4 програмын даалгаврыг боловсруулан хүргүүлсэн.</p>	
6	Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх	<p>Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэргэжлийн болон үйлчилгээний үр чадварыг дээшлүүлж, мэргэшүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах</p> <p>Шатлан дэвших журмыг хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах, сул орон тоонд төрийн албан хаагчдыг хууль, журмын дагуу томилох ажлыг хэрэгжүүлэх</p> <p>Авлигын эсрэг сургалт сурталчилгаа зохион байгуулах</p>	<p>Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдал хангагдсан байна</p> <p>Холбогдох ажилтнууд сургалтад хамрагдсан байна.</p> <p>Албан хаагчдын 80 орчим хувийг хамруулсан байх</p>	<p>2019 оны жилийн эцсийн байдлаар албан хаагчдыг мэргэшүүлэх, үр чадварыг дээшлүүлэх чиглэлээр нийт 644 удаагийн сургалтад 13231 албан хаагчийг (НДХ-үүдийн жилийн эцсийн тайлангийн нэгтгэлийн дүнд-давхардсан тоогоор) хамрууллаа. Үүнээс тус газар нь 53 удаагийн сургалтад нийт 3244 (мэдээллийн цагт оролцогчдын тоог 1105 хүн оруулсан-давхардсан тоо) удирдах болон гүйцэтгэх түвшний албан хаагчдыг хамруулан сургалтуудыг зохион байгуулаад байна.</p> <p>Удирдлагын академийн эрхэлсэн, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 10 удирдах ажилтан бүрэн хамрагдсан. Төрийн албаны шинэчилсэн хуулийн дагуу мерит зарчмаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын 4 албан хаагч, албан тушаал дэвшүүлэн томилогдсон байна.</p> <p>Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, албан хаагчдын авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Төрийн албан хаагчдыг авлига, ашиг сонирхол, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургалтыг салбарын хэмжээнд зохион байгуулж, 80 гаруй хувь нь хамрагдаад байна.</p>	96.7
<b>Дундаж үнэлгээ</b>					<b>98.2</b>

Үнэлгээг баталгаажуулсан: Дотоод аудит, мониторингийн газрын дарга

Ц.Алтангэрэл

Биелэлт нэгтгэсэн: Тамгын газрын ахлах мэргэжилтэн, ЭБАТ



Г.Сурахбаяр



**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРААС 2019 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/2019 оны жилийн эцсийн байдлаар /

**Нэг. Хяналт- шинжилгээ, үнэлгээний зорилго:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тухайн жилд тавьсан зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан хэрэгжилтийн түвшинг тогтоох, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Арга зүй, ашигласан эх сурвалж:**

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2019 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын тайлан, холбогдох мэдээ, мэдээллийг үндэслэсэн болно.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн:**

Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51-р тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр 6 зорилтын 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсаныг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРААС 2019 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ЯВЦЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО**

Зорилт	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо					Хэрэгжилт хувь
			100 /90-100/	70 /60-69/	40 /31-59/	0 /0-30/	/-/	
<u>Зорилт 1:</u> Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх	1	3	3					100
<u>Зорилт 2:</u> Өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл гомдол, мэдээллийг	1	1	1					100

цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх								
<i>Зорилт 3:</i> Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох	1	1	1					100
<i>Зорилт 4:</i> Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаархи судалгааг тогтмол хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах	1	1	1					95
<i>Зорилт 5:</i> Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	1	3	3					97,9
<i>Зорилт 6:</i> Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх	1	3	3					96,7

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг үзүүлбэл:

Уг төлөвлөгөөнд тусгагдсан нийт 6 зорилт бүхий 12 арга хэмжээ байна. Үүнээс:

“Үр дүнтэй” буюу 100 хувийн биелэлттэй:

Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалтын ажил бүрэн хийгдсэн, тодорхой үр дүн гарсан 9 арга хэмжээ:

- *Зорилт 1.1.* Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч, ажилтан, ажил олгогч болон даатгуулагч-үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг үнэлэх арга хэмжээг зохион байгуулах, санал, дүгнэлт боловсруулах;
- *Зорилт 1.2.* Төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор төрийн байгууллагууд /Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Архивын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар зэрэг/-тай цахимаар мэдээлэл солилцох, хамтран ажиллах ;

- Зорилт 1.3. Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор Архивын ерөнхий газар, нийслэл, орон нутгийн, цэргийн архивын байгууллагуудаас архивын лавлагааг цахимаар хүлээн авах ажиллагааг эхлүүлэх, хамтран ажиллах;
- Зорилт 2.1. Нийгмийн даатгалын мэдээллийн лавлах 77771289 утасны үйл ажиллагааг өргөжүүлэх, байгууллагын цахим хуудас, FB хуудсанд ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэлд цахим хэлбэрээр хариу өгөх, шийдвэрлэхэд хяналт тавих;
- Зорилт 3.1. Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох;
- Зорилт 5.2. Нийгмийн даатгалын өгөгдлийн санг цуглуулах, нэгтгэх, нөөцлөх, хадгалах болон иргэд, даатгуулагчид, төрийн байгууллагуудад мэдээллийн үйлчилгээ үзүүлэх;
- Зорилт 5.3. Сайн дурын даатгалын гэрээг цахим хэлбэрээр байгуулах ажлыг зохион байгуулах, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллах;
- Зорилт 6.1. Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэргэжлийн болон үйлчилгээний ур чадварыг дээшлүүлж, мэргэшүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах;
- Зорилт 6.3. Авлигын эсрэг сургалт сурталчилгаа зохион байгуулах.

#### 90-95 хувийн биелэлттэй:

- Зорилт 4.1. Нийгмийн даатгалын үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгааг авах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах /95/;
- Зорилт 5.1. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг тоон гарын үсэг ашиглан хүлээн авах, баталгаажуулах ажлыг өргөжүүлэх /93.9/;
- Зорилт 6.2. Шатлан дэвших журмыг хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах, сул орон тоонд төрийн албан хаагчдыг хууль, журмын дагуу томилох ажлыг хэрэгжүүлэх /90/.

#### **Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж**

1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц 2019 оны жилийн эцсийн байдлаар 98.2 хувьтай дүгнэгдэв.

Хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрээр авч үзвэл:

- 100 хувийн биелэлттэй 9 арга хэмжээ
- 90-95 хувийн биелэлттэй 3 арга хэмжээ байна.

2. Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа харьцангуй шуурхай хийгдэж байгаа нь жилийн ажлын явц, үр дүнгээс харагдаж байна.
3. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангах, зорилтот түвшинд хүргэх, ажлын гүйцэтгэлийг эрчимжүүлэх, заалтыг бүрэн хэрэгжүүлж дуусгахад

анхаарч, хэрэгжилтийн түвшин, үр дүнг дээшлүүлж ажиллахыг тус тус зөвлөмж болгож байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хийсэн үнэлгээний тайланг хавсаргав.

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН ГАЗАР